

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал	12
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	0
4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	0
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	2
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	3
4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	4
4.5 Зорилтот түвшин, гүйцэтгэл	26
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат компани
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020 03.13 № 03/880
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон бусад илчлэл тодруулга тайланг Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон бусад хууль, тогтоомжийн дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын Захирал А.Бямбадорж Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн авлага, өр төлбөр, урьдчилж орсон орлогын гүйлгээг стандартын дагуу бүртгэх, хуримтлагдсан авлагыг барагдуулах, мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС, болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, тодруулгыг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 03-наас 2020 оны 3 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Нийслэл аудит” ХХК-ийн чанарын хяналтын менежер С.Сэрчхорол, аудитор Л.Ганзориг, аудитор Д.Жаргал, шинжээч Д.Долгор, аудиторын туслах Д.Ариунцэцэг нар хариуцан хэрэгжүүлэв.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ нь 2019 оны санхүүгийн тайланг “Нийслэл аудит” ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 01/140 дугаар албан бичгээр хуульд заасан цагалбарт хугацааг 2 хоног хоцроож ирүүлсэн болно.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ нь эрчим хүчний салбарт улсын төсвийн болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөр, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавих, эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, дүгнэлт гаргах, эрчим хүчний хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгох, мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажилладаг байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 308 дугаар тогтоолд “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Эрчим хүчний салбарт улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, концесс, гадаад хамтын ажиллагаа, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд гэрээгээр ажил гүйцэтгэх, захиалагчийн хяналт тавих;
- Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах, тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилан дүгнэлт гаргах, түүнтэй холбогдох бусад ажлуудыг зохион байгуулах;
- Салбарын ажилтныг мэргэжил эзэмшүүлэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшсэн зөвлөх инженерийн зэрэг олгох, төсөвчний анхан шатны болон зэрэг олгох сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- Цахилгаан болон дамжуулалтын зуух, турбин тоноглолын найдвартай байдлыг хангах зорилгоор эрчим хүчний салбарын сорил шинжилгээний лаборатори ажиллуулах;
- Иргэн, хуулийн этгээдийн эрчим хүчний бодит хэрэглээ, эрчим хүчний зардал, барилга, байгууламжийн хийцэд тооцоо, судалгаа, дүн шинжилгээ хийх, хэмнэх боломжийн талаар ерөнхий дүгнэлт боловсруулж, зөвлөмж гаргах;
- Эрчим хүчний чиглэлээр олон улсын болон дотоодын хурал уулзалт зохион байгуулах, оролцох, туршлага судлах;

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээ татвар ногдуулах орлогын хэмжээнээс хамаарч өөрчлөгдсөн;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Diamond” программ хангамж ашигладаг байна.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 23,677.6 сая төгрөгөөс тооцон 236.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг тооцоолоогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 540.6 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	557.7	299.4	(258.3)
Авлага	993.6	1,026.4	32.8
Татвар, НДШ-ийн авлага	0.2		(0.2)
Бараа материал	384.9	309.5	(75.3)
Урьдчилж төлсөн зардал тооцоо	71.2	120.0	48.8
Үндсэн хөрөнгө	10,741.7	10,468.3	(273.4)
Биет бус хөрөнгө	11,681.9	11,667.0	(14.9)
Нийт хөрөнгө	24,431.2	23,890.6	(540.6)
Дансны өглөг	150.1	456.9	306.8
Татварын өр	1.1	126.8	125.7
НДШ-ийн өглөг		155.9	155.9
Урьдчилж орсон орлого	2,069.5	937.6	(1,131.9)
Урт хугацаат зээл	3,731.1	3,731.1	0.0
Өмч:-төрийн	2,637.3	2,637.3	0.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,888.2	1,888.2	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг	12,740.9	12,740.9	0.0
Хуримтлагдсан ашиг	1,212.9	1,215.9	3.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	24,431.2	23,890.6	(540.6)

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны 1,028.4 сая төгрөгийн үлдэгдлээс авлагын эзэн нь тодорхойгүй, холбогдогч хуулийн этгээд татан буугдсан, хаягийн бүртгэлгүй зэрэг шалтгаанаар баталгаажигдаагүй байгууллага, хувь хүмүүсээс авах хүлээн зөвшөөрдөггүй тооцоо нийлэх, бууруулах боломжгүй 601.0 сая төгрөгийн авлага байна.

Авлагын бусад данс дахь 623.7 сая төгрөгийн үлдэгдлийг авч үзвэл: Аж ахуйн нэгж байгууллагаас авах авлага дансанд Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төвийн ажиллагсдын нийгмийн баталгааг хангах зорилгоор Түмэн-Алт ХХК-тай 2014 оны 6 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан барилгын ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой үүссэн 365.7 сая төгрөгийн шүүхээр шийдвэрлүүлэх авлага, Улаанбаатар Дарханы автозамын гэрэлтүүлэг, Улиастайн гүүрнээс Налайх хүртэлх замын ажил зэрэгтэй холбоотой үүссэн УБЦТС ТӨХК-иас авах 53.4 сая, Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-аас 32.0 сая, химийн болон металлын лабораторийн шинжилгээтэй холбоотойгоор үүссэн харьяа үйлдвэрийн газрууд, аж ахуйн нэгжээс авах 61.6 сая, сургалтын үйл ажиллагаа явуулснаас үүссэн эрчим хүчний салбарт үйл ажиллагаа эрхэлдэг компаниудаас авах 27.8 сая, төрийн өмч, хөрөнгө түрээсэлсэн байгууллагуудаас авах авлага 6.8 сая, зураг төслийг магадлан дүгнэлт гаргаснаас 22.0 сая, хэвлэх цехээс үйлдвэрлэн гаргадаг ном, гарын авлага, захиалгат хэвлэлүүдийг борлуулснаас үүссэн харьяа газрууд болон бусад аж ахуйн нэгжүүдээс авах 17.9 сая, ажилтан албан хаагчдаас авах 5.5 сая, нийтдээ 623.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэл авлагын бусад данс байна.

Өмнөх жилүүдэд байгуулсан найдваргүй авлагын нөөцийн үлдэгдэл 200.0 сая төгрөг байна.

Бараа материалын 309.5 сая төгрөгийн үлдэгдэлд түүхий эд, бичиг хэрэг, аж ахуй болон сургалтын материалууд, сэлбэг хэрэгсэл, химийн бодис, хангамжийн материал, бэлэн бүтээгдэхүүн зэрэг байна. Байгууллагын өмч хамгааллын байнгын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэл, мөн оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хангамжийн материалыг данснаас хасах тухай А/95 тоот захирлын тушаалын дагуу балансад бүртгэлтэй байгаа ашиглах боломжгүй болсон 170 нэр төрлийн 86.9 сая төгрөгийн үнэ бүхий хангамжийн материалыг данс бүртгэлээс хассан нь бараа материалын бууралтад голлон нөлөөлсөн байна.

Урьдчилж төлсөн зардал, тооцоо данс үлдэгдэл нь Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах дэд станц барих БНХАУ-ын Засгийн газрын зээлийн санхүүжилтээр хийгдэж буй төсөлд олгосон 49.8 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр, тайлант хугацаанд үүссэн хаагдаагүй албан томилолтын тооцоо 11.4 сая, 1.1 сая төгрөгийн шатахууны тооцоо, хангамжийн материал бэлтгэхэд зориулж бэлтгэн нийлүүлэгчид төлсөн 3.1 сая, 2019 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн Монгол даатгал компанитай байгуулсан үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгсэл даатгах ЭХХТ/85/2019 тоот гэрээнд тусгагдсан даатгалын нийт хураамж болох 63.0 сая төгрөгөөс тайлант хугацааны даатгалын зардлаар тусгагдаагүй 52.5 сая төгрөг тус бүрээс бүрдэж байна.

Үндсэн хөрөнгө данс ТӨБЗГ-ын 2018 оны 403 дугаар тогтоолоор баригдсан 280.4 сая төгрөгийн гараашийн өргөтгөлийн барилга, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс 15.4 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлж авсан, Монхорус Интернейшнл ХХК-с хандивласан тусламжийн хөрөнгөөр 102.9 сая төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж болон ТӨБЗГ-ын 2019 оны 473 дугаар тогтоолын дагуу 30.0 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 140.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 101.7 сая төгрөгөөр компьютер, дагалдах хэрэгсэл зэргийг худалдаж авсан дүнгээр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд нийт 715.3 сая төгрөгийн элэгдэл тооцоолсон байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл Монгол даатгал компанитай байгуулсан 63.0 сая төгрөгийн тээврийн хэрэгслийн даатгалын төлбөр, худалдан авсан үндсэн хөрөнгийн

үлдэгдэл тооцоо 65.0 сая, гадаад сургалттай холбоотой тооцооны өглөг 29.0 сая төгрөг, 36.9 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн татварын өглөг, УБ-Мандалговийн цахилгаан дамжуулах дэд станцын ажлын өглөгийг зэргээс шалтгаалан өссөн байна.

Урьдчилж орсон орлогын бууралт нь тайлант хугацааны үйл ажиллагааны орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Эгийн голын усан цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх зорилгоор Сангийн яам болон Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төв ТӨААТҮГ-ын хооронд анх 2006 оны 07-р сарын 26-ны өдөр байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээтэй холбоотойгоор үүссэн 3,731.1 сая төгрөгийн урт хугацаат зээл балансаас баланс дамжин бүртгэгдсэн өр байна.

Тайлант хугацаанд 2018 оны ногдол ашигт 1.5 сая төгрөгийг хуваарилсан байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу зорилтын саналыг, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Төрийн өмчит хуулийн этгээд дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” гэж заасныг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрчим хүчний яамны сайдын 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 473 дугаар тушаалаар Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын 2019 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний шинэчилсэн төлөвлөгөөг 6,276.7 сая төгрөгийн орлоготой, 6,276.5 сая төгрөгийн зардалтай, 0.2 сая төгрөгийн ашигтай байхаар баталжээ.

Зорилтот түвшний төлөвлөгөөгөөр техник хяналтын орлого 4,601.5 сая, зураг төсөл магадлалын орлого 390.0 сая, лабораторийн орлого 406.0 сая, сургалтын орлого 613.7 сая, түрээсийн орлого 88.4 сая, 177.0 сая төгрөгийн туслах үйл ажиллагааны орлого бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр хяналтын орлого 4,067.2 сая төгрөг буюу 88.4 хувиар, зураг төсөл магадлалын орлого 347.7 сая төгрөг буюу 89.2 хувиар, сургалтын орлого 885.9 сая төгрөг буюу 144.4 хувиар, лабораторийн орлого 377.2 сая төгрөг буюу 92.9 хувиар, түрээсийн орлого 91.6 сая төгрөг буюу 103.6 хувиар, туслах үйл ажиллагааны орлого 311.5 сая төгрөг буюу 175.9 хувиар тус тус биелсэн байна. Үүнээс сургалтын орлого 272.2 сая, түрээсийн орлого 3.2 сая, туслах үйл ажиллагааны орлого 134.4 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлж, техник хяналтын орлого 534.3 сая төгрөгөөр, зураг төсөл магадлалын орлого 42.3 сая төгрөгөөр, лабораторийн орлого 28.8 сая төгрөгөөр тус тус тасарч, нийт дүнгээр 189.0 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Гадаад сургалт зохион байгуулж 222.9 сая төгрөгийн сургалтын орлогыг нэмэлтээр, 2019 оны 5 дугаар сараас 1 давхрын талбайг түрээслүүлж эхэлсэнтэй холбоотойгоор 2.4 сая төгрөгийн түрээсийн орлого, хэвлэх цехийн захиалгын хэмжээ нэмэгдсэн, 134.7 сая төгрөгийн орлогыг Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс гэрээний дагуу оруулсан зэрэг нь үндсэн борлуулалтын орлогын төлөвлөгөө тасарсныг нөхөхөд хүргэсэн байна.

Тайлант хугацаанд 6,276.5 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөснөөс 5,974.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 302.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Батлагдсан төлөвлөгөөнөөс илүү, дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

- Харуул, хамгаалалтын зардал 0.9 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь 2019 оны 08 дугаар сард хийсэн гэрээгээр хамгаалалтын гэрээт ажлын санхүүжилт нь ажилчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, үнийн өсөлттэй холбоотойгоор 2018 оноос 3.6 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.
- Сургалтын зардал 160.9 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь эрчим хүчний салбарын үйлдвэр компаниудын хүсэлтийн дагуу инженер техникийн ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор Австрали болон Франц улсууд руу үйлдвэр компаниудын сургалтын зардлаар сургалт зохион байгуулснаас шалтгаалсан.

- Элэгдэл хорогдлын зардал 55.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь 2019 оны тодотголоор хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг багасгасантай холбоотойгоор ихэнх худалдан авалт хийгдээгүйтэй холбоотой.
- Албан томилолтын зардал 22.6 сая төгрөгөөр хэмнэсэн нь Улаанбаатар хотод байрлах эрчим хүчний үйлдвэр компаниудад хийх үзлэг 10 дугаар сард дууссан, орон нутагт байрлах үйлдвэр компаниудад хийх хяналт шалгалт он дамжин хийгдэх болсноос тус тус шалтгаалжээ.
- Цалин, НДШ-ийн зардал 136.3 сая төгрөгөөр хэмнэсэн нь зарим төсөл арга хэмжээ удааширч, зогссонтой холбоотойгоор орлого багассан нь ажилчдын үр дүнгийн шагналт цалинг бууруулахад хүргэж нийт цалин буурахад нөлөөлсөн. Цалингийн зардал буурсантай холбоотойгоор НДШ-ийн зардал мөн буурсан байна.

Орлогын төлөвлөгөө тасарсан ч, зардлын хэмнэлтээс шалтгаалж төлөвлөсөн ашиг нэмэгдэж 16.0 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 15 эрсдэл тодорхойлж нийт 14 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 364.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 251.8 сая төгрөгийн алдааг залруулж, 96.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 16.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

1. Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах алдаа, зөрчлийг залруулан санхүүгийн тайланд тусгаж, удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:
 - Найдваргүй авлагын хасагдуулга дансанд 215.0 сая төгрөгийн гүйлгээг тодорхой тушаал, судалгаа, үндэслэлгүй хийсэн нь тус байгууллагын мөрдөж буй НБББББ-т буй авлагын бүртгэлийн бодлогын үнэлгээ, толилуулга хэсэгт тусгасан найдваргүй авлагын бүртгэлтэй, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйл 5.1.3-ийн “жинхэнэ хэрэгжилтийн” зарчимтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

- Тайлант онд урьдчилж орсон орлогыг 3.7 сая төгрөгөөр бууруулж өмнөх үеийн ашиг дансыг, зураг төслийн магадлалын авлага дансыг 6.7 сая төгрөгөөр бууруулж урьдчилж тооцсон орлогыг нэмэгдүүлсэн, авлагын дансыг 0.6 сая төгрөгөөр бууруулсан залруулах бичилтүүдийг холбогдох тушаал, шийдвэргүйгээр данс бүртгэлд тусгасан нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйл 5.1.3 “жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалтуудтай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

- Германы хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-ээс 15.4 сая төгрөгийн үнэ бүхий компьютер болон дагалдах хэрэгсэл хандиваар өгснийг хандивын капитал дансанд бүртгэсэн нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн зааварт “аж ахуйн нэгж нь үнэ төлбөргүйгээр буюу буцалтгүй тусламж, бэлэг, хандиваар үндсэн хөрөнгийг олж бэлтгэсэн бол хүлээн авсан хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрч, тайлант үеийн орлого/хойшлогдсон орлогоор хүлээн зөвшөөрнө” гэж тусгасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

- Тайлант хугацааны санхүүгийн программын лицензийн төлбөр болох 2.6 сая төгрөгийг авлагын данс дамжуулж бүртгэлд тусгасан нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-т тусгасан өр төлбөрийн бүртгэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

- Тайлант хугацаанд банкны харилцах дансын үлдэгдэлд тооцон олгосон 7.8 сая төгрөгийн хүүгийн орлогод 10 хувийн орлогын албан татварыг ногдуулаагүй нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.6.3-д “хүүгийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо албан татвар ногдох тухайн орлогын нийт дүнгээр тооцно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

- Санхүү байдлын тайлан дээрх 59.3 сая төгрөгийн авлага, 36.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Залруулагдаагүй 16.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар хөрөнгийн биет тооллогод биечлэн оролцож тооллогын явц, зарим нэр төрлийн хөрөнгийн тоо хэмжээг биетээр байгаа эсэхийг нягтлах, мөн урт хугацаат өр төлбөр болон дуусаагүй барилгатай холбоотой асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн <http://edc.energy.gov.mn/scat/13#> цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж байна. Тайлант хугацаанд шилэн дансны стандартыг баримтлан шилэн дансны сайтад мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв оруулж дараах мэдээг хүргэсэн байна. Тайлант жилд шилэн дансны цахим хуудсанд нийт 148 төрлийн мэдээллийг байршуулахаас 138 мэдээллийг хугацаанд, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Залруулагдаагүй 112.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 236.8 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Томилолтын зардалтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт

Тайлант хугацаанд гарсан томилолтын зардлыг тооцож үзэхэд 16.8 сая төгрөгийн албан томилолтын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл

Хөрөнгө шамшигдах, хууль, дүрэм, журам хэрэгжихгүй байх, үйл ажиллагааны зардал илүү тооцогдох;

3.1.3 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх, анхан шатны баримт бүрдлийг дээд газрын холбогдох албан тушаалтнуудаас бүрэн авч ажиллах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Анхан шатны маягттай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт

Тус байгууллага нь хүчингүй болсон Сангийн сайдын 2002 оны тушаалаар батлагдсан бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдөл, бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт, мөнгөн урьдчилгааны баримт, бараа материалын орлогын, зарлагын баримт, шаардах хуудас, зэрэг анхан шатны бүртгэлийн маягтыг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Энэ нь “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна;

3.2.2 Эрсдэл

Холбогдох хууль, дүрэм, журам журмыг зөрчих, биелүүлэхгүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар"-ыг бүртгэлийн үйл ажиллагаандаа хэрэглэх;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Урьдчилж тооцсон орлогын бүртгэлийн талаар

3.3.1 Илрүүлэлт

Тайлант онд тус төв нь авлагын данс /Хими болон метал лабораторийн авлага, сургалт, түрээс, буудал, хэвлэх цех, харьяа үйлдвэрүүдээс авах авлага/, болон өр төлбөрийн данс /Хими болон металл лаборатори, сургалт, түрээс, буудал, хэвлэх цех, техник хяналтын урьдчилж тооцсон орлого/-ыг нэгэн зэрэг нэмэгдүүлсэн буруу бичилт хийсэн нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-ыг зөрчиж, тус байгууллагын мөрдөж буй НБББББ-т тусгагдсан авлага, өр төлбөрийн бүртгэлийн горимтой нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл

Холбогдох заавар, НБББББ зэргийг мөрдөөгүйгээс авлага, урьдчилж орсон орлогыг буруу бүртгэх, харилцагчийн тооцоо зөрөх, тайлант хугацааны орлого илүү болон дутуу илэрхийлэгдэх;

3.3.3 Өгсөн зөвлөмж

Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-ыг мөрдөх, байгууллагын НБББББ-ийг шинэчлэн боловсруулах;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Эрчим хүчний газраас шилжиж ирсэн авлагын талаар

3.4.1 Илрүүлэлт

Эрчим хүчний газар байх үед буюу 2007-2012 онд үүссэн гэгдэх 34 аж ахуйн нэгж, 6 хувь хүмүүсээс авах авлагыг хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулах ажлыг зохион байгуулсан ч авлага баталгаажаагүй байна.

3.4.2 Эрсдэл

Хууль, тогтоомж хэрэгжихгүй байх, төрийн өмч хөрөнгө шамшигдах, санхүүгийн тайлан болон үзүүлэлтүүд буруу илэрхийлэгдэх;

3.4.3 Өгсөн зөвлөмж

Эзэн холбогдогч тодорхойгүй авлагыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх;

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дээд газраар уг авлагыг шийдвэрлүүлнэ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

3.5.1 Илрүүлэлт

Компанид ашиглаж буй НБББББ-т 2013 оноос хойш нэмэлт өөрчлөлт хийгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна;

3.5.2 Эрсдэл

Шинээр батлагдсан хууль тогтоомж, стандартыг биелүүлэхгүй байх, зөрчих, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа доголдох;

3.5.3 Өгсөн зөвлөмж

НБББББ-ийг шинэчлэн батлаж, үйл ажиллагаандаа мөрдөх, байгууллагын онцлогт тохирсон тусгай бодлогуудыг уг баримт бичигт тусгах;

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

НБББББ-ийг шинэчлэн боловсруулж мөрдөн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	557,706,198.25	299,390,527.27
1.1.2	Дансны авлага	993,605,840.95	1,026,443,246.24
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	248,855.00	
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	384,852,902.64	309,523,799.24
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	71,190,420.34	119,987,420.64
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,007,604,217.18	1,755,344,993.39
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	10,741,684,392.75	10,468,306,842.84
1.2.2	Биет бус хөрөнгө	11,681,896,516.85	11,666,981,981.76
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	22,423,580,909.60	22,135,288,824.60
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	24,431,185,126.78	23,890,633,817.99
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	150,147,690.56	456,855,039.21
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	1,110,117.90	126,818,047.96
2.1.1.4	НДШ–ийн өглөг		155,942,895.88
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,069,496,193.12	937,582,343.29
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,220,754,001.58	1,677,198,326.34
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	3,731,110,140.00	3,731,110,140.00
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,731,110,140.00	3,731,110,140.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	5,951,864,141.58	5,408,308,466.34
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	2,637,320,333.16	2,637,320,333.16
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,888,197,225.37	1,888,197,225.37
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	12,740,903,531.19	12,740,903,531.19
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,212,899,895.48	1,215,904,261.93
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	18,479,320,985.20	18,482,325,351.65
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	24,431,185,126.78	23,890,633,817.99

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2019 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	7,064,962,428.03	5,678,013,824.19
2	Борлуулалтын өртөг	53,272,843.74	56,164,589.67
3	Нийт ашиг(алдагдал)	7,011,689,584.29	5,621,849,234.52
4	Түрээсийн орлого	96,450,000.00	91,625,900.00
5	Хүүгийн орлого	6,498,117.54	7,811,695.56
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	134,792,843.27	310,248,545.66
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	7,128,383,009.76	5,917,845,760.93
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	10,736,779.57	1,163,695.34
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(120,683,135.92)	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		(98,864,953.53)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	11,101,178.99	15,988,356.62
19	Орлогын татварын зардал	1,110,117.90	11,485,331.02
20	Татварын дараах ашиг (алдагдал)	9,991,061.09	4,503,025.61
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	9,991,061.09	4,503,025.61
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,637,320,333.16	1,075,302,847.21	1,073,824,953.41	1,239,666,844.39	6,026,114,978.17
3	Залруулсан үлдэгдэл	2,637,320,333.16	1,075,302,847.21	1,073,824,953.41	1,239,666,844.39	6,026,114,978.17
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				2,876,840.00	2,876,840.00
5	Бусад дэлгэрэнгүй орлого			14,277,777.78		14,277,777.78
6	Өмчид гарсан өөрчлөлт				(39,634,850.00)	(39,634,850.00)
7	Зарласан ногдол ашиг				9,991,061.09	9,991,061.09
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		812,894,378.16	11,652,800,800.00		12,465,695,178.16
9	2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,637,320,333.16	1,888,197,225.37	12,740,903,531.19	1,212,899,895.48	18,479,320,985.20
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл	2,637,320,333.16	1,888,197,225.37	12,740,903,531.19	1,212,899,895.48	18,479,320,985.20
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт				(1,498,659.16)	(1,498,659.16)
15	Зарласан ногдол ашиг				4,503,025.61	4,503,025.61
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
17	2019 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,637,320,333.16	1,888,197,225.37	12,740,903,531.19	1,215,904,261.93	18,482,325,351.65

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,489,182,893.62	4,702,306,530.85
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,315,996,009.00	4,641,920,510.05
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	80,620,039.00	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	92,566,845.62	60,386,020.80
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(7,110,500,095.08)	(4,750,173,386.57)
1.2.1	Ажиллагчдад төлсөн	(3,002,704,991.04)	(2,796,425,173.70)
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(716,530,609.00)	(586,488,473.29)
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	(691,942,129.00)	(552,967,168.60)
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	(62,681,413.23)	(59,969,303.19)
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(55,800,000.00)	(44,908,690.00)
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	(388,935,916.00)	(182,826,216.00)
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	(57,463,854.00)	(22,168,532.00)
1.2.9	Бусад мөнгөн зарлага	(2,134,441,182.81)	(504,419,829.79)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(621,317,201.46)	(47,866,855.72)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,498,117.54	8,711,695.56
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	6,498,117.54	8,711,695.56
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(56,980,000.00)	(426,505,292.20)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(53,680,000.00)	(426,505,292.20)
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(3,300,000.00)	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6			

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(50,481,882.46)	(417,793,596.64)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,000,000.00	206,181,086.04
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	8,000,000.00	206,181,086.04
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	22,093,003.69	208,177,179.65
4	Валютын ханшийн зөрүү	10,733,474.77	1,163,695.34
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(653,065,609.15)	(258,315,670.98)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,210,771,807.40	557,706,198.25
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	557,706,198.25	299,390,527.27

4.5 Зорилтот түвшин, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого	6,276.7	6,088.9	(187.8)	97.0
Техник хяналт орлого	4,601.5	4,067.2	(534.3)	88.4
Зураг төсөл магадлалын орлого	390.0	347.7	(42.3)	89.2
Лабораторийн хэлтэсийн орлого	406.0	377.2	(28.8)	92.9
Сургалтын орлого	613.7	885.9	272.2	144.4
Борлуулалтын орлого	6,011.2	5,678.0	(333.2)	94.5
Түрээсийн орлого	88.4	91.6	3.2	103.6
Хүүгийн орлого	-	7.8	7.8	
Бусад орлого /Хэвлэх цех, ҮҮА /	177.1	311.5	134.4	175.9
Нийт зардал	6,276.5	5,974.0	(302.5)	95.2
Үүнээс: Удирдлагын зардал	222.2	3.1	(219.1)	1.4
Татварын өмнөх ашиг / алдагдал /	196.5	114.9	(81.6)	58.5
Цэвэр ашиг / алдагдал /	176.9	11.5	(165.4)	6.5
Төрийн өмчийн ногдол ашиг	17.7	1.1	(16.6)	6.5
Нийт ажиллагсадын тоо	126.0	123.0	(3.0)	97.6
Нийт цалингийн сан	3,177.4	3,056.3	(121.1)	96.2
Нэг ажилтны дундаж цалин	2.1	2.1	(0.0)	98.6
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.0	1.0	0.0	101.9
Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ,	309.6	323.6	14.0	104.5
Авлага	895.8	1,026.4	130.6	114.6
Үүнээс: Найдваргүй авлага	635.0	601.0	(34.0)	94.6
Өглөг	3,903.4	4,470.7	567.3	114.5
Үүнээс: Богино хугацаат өглөг	172.3	739.6	567.3	429.3
Урт хугацаат өглөг	3,731.1	3,731.1	-	100.0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2020.03.19			САГ-2020/61/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Авллага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	96.1	Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	А.Бямбадорж Д.Эрдэнэчимэг
	Албан томилолтын анхан шатны баримтын бүрдэл дутуу	16.8	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	А.Бямбадорж Д.Эрдэнэчимэг
	Дүн	112.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25 № 01/183
САН 2020/61/СТА-ТӨМГ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Энэ нь Санхүү байдлын тайлан дээрх 59.3 сая төгрөгийн авлага, 36.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайланд толилуулсан авлага, өглөгийн үлдэгдлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасны дагуу тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд тусгах
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Эрчим Хүчний Хөгжлийн Төв” ТӨААТҮГ-ын дарга А.Бямбадорж, нягтлан бодогч Д.Эрдэнэчимэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ХОСЖАРГАЛ

“НИЙСЛЭЛ АУДИТ” ХХК
ЗАХИРАЛ

Т.СУГАРСҮРЭН

ЗӨВШӨӨРСӨН:

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ”
ТӨААТҮГ-ЫН ДАРГА

А.БЯМБАДОРЖ
НЯГТЛАН БОДОГЧ

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагын тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь эзлэх тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.